

## **“МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ” СЭДЭВТ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

2015.11.03-ны өдөр.

Улаанбаатар зочид буудал. Хархорин танхим.

*ННФ-ын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам:* “Монгол Улсын 2016 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг эхэлж байна. Хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье. Хэлэлцүүлгийг ННФ-ын Удирдах зөвлөлийн дарга Г.Уранцоож нээж үг хэлнэ.

*ННФ-ын Удирдах зөвлөлийн дарга Г.Уранцоож:* Төсөв бол хөгжлийг илэрхийлдэг. Манай төсөв бол үндэсний хөгжлийн бодлоготой хэр зэрэг уялдаж байдаг талаар бидэнд ойлголт байхгүй. Иргэд төсвөө хянана гэдэг сүлжээний ТББ-ын хүмүүс сууж байна. Энэ хүмүүс үнэтэй санал хэлэх байх. Төр гэдэг нь хүний эрхийг хангах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхэд төсвөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Төсвийн хэлэлцүүлэг нь хэр зэрэг нээлттэй, ил тод байгаа, хэр зэрэг оролцоотой байна гэдэг нь чухал. Жил бүрийн төсөв бодит байдлаас давсан төлөвлөлт хийгддэг. Зарлага нь мөн адил үр дүнтэй зарцуулагддаг гэдэг дээр иргэд төдийлөн итгэлтэй байдаггүй. Төсвийн орлого зарлагын төлөвлөлт дээр манай ННФ-аас хөндлөнгийн дүгнэлт хийж ажиллаж, тодорхой зөвлөмж өгч ирсэн. Төсөвт маш их орлогыг бодит бусаар оруулж, үр ашиггүй зарлагыг төлөвлөдөг байдал үргэлжилсээр байна. Энэ төсвийг хэлэлцүүлж байгаа үед УИХ-ын төсвийн байнгын хорооноос хүн суух ёстой байсан байх. Гэхдээ хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа нь цагаа олсон зүйл юм. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж, үр ашиг нь чухал юм. Хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд амжилт хүсье.

**“Монгол улсын 2016 оны төсвийн орлогын төлөвлөлт” (илтгэл)** сэдвээр Сангийн яамны орлогын хэлтсийн мэргэжилтэн У.Мөнхзул илтгэл танилцуулав.

У.Мөнхзул: Төсвийн орлогын төлөвлөлтийн танилцуулгын агуулгад төсвийн орлого төлөвлөлтөд баримталсан зарчим, үндсэн төсөөлөл, нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлтүүд, татварын орлого ба эдийн засаг дахь татварын ачаалал, уул уурхайн салбарын төсвийн орлогод үзүүлэх нөлөө, импортын хэмжээ, импортоос хамааралтай орлого, татварын бус орлого багтсан.

Төсвийн орлого төлөвлөлт, зарчим:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон (Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл)
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлнэ. Түүнчлэн, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн үр дүнд татварын бааз суурь өснө.
- “Таван толгойн”-н бүлэг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, мөн “Оюу толгой” төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын үйл ажиллагаа үргэлжилнэ гэж тооцов.

- Уул уурхайн бүтээгдэхүүнийн үнийн төсөөлөл хийдэг олон улсын банк, санхүүгийн байгууллагын таамаглал, судалгааг ашигласан.
- Эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээний төсөөллийг Уул уурхайн яам болон томоохон олборлогч аж ахуйн нэгжүүдээс авсан.

Зэсийн үнэ өнгөрсөн 20 жилийн дунджаар 4425.43 ам.доллар байгаа ба графикаар харуулав.

Нэгдсэн төсвийн орлого, орлогын үзүүлэлтүүд, татварын орлого ба эдийн засаг дахь татварын ачаалал, уул уурхайн салбарын орлогын төсөвт үзүүлэх нөлөөлөл, уул уурхайн салбарын орлого, импортоос хамаарсан орлогууд, татварын бус орлогуудыг слайд дээр үзүүлэв. Ингээд асуулт байвал авъя.

*Хэлэлцүүлэгт оролцогч Б.Мөнхсоёл:* Өмнө нь би ННФ-д ажиллаж байсан. Энэ арга хэмжээ маань үргэлжлээд явж байгаад талархаж байна. Бид бүгд төсвийн орлогыг өөдрөгөөр төлөвлөдөг. Мэдсээр байгаад бид алдагдалтай төсөв батлаад, оны эцэст нь орлого бүрддэггүй, үүнээс болж төсвийн тодотголыг нэг бус удаа хийж ирлээ. Ямар нэг хэмжээгээр улс төрийн нөлөө, Засгийн газрын бусад нөлөө орсоноор төсвийн алдагдлын хэмжээ өсч байна. Жил бүр энэ асуудал давтагддаг. Сүүлийн 3 жилд төсвийн алдагдал 3 их наяд хэмжээнд хүрсэн байна. Сангийн яамныхан төсвийг УИХ-д оруулахдаа эрсдлээ тооцдог байх, эрсдлээ бууруулах талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, одоо бүр нөхцөл байдалдаа тааруулж хуулиа өөрчилдөг болсон. Төгрөгийн доллартай харьцах харьцааг маш багаар тооцдог зэрэг дутагдал. Энэ бүхнээс гарахын тулд төсөвт улс төрийн оролцоог багасгах талаар юу хийх вэ. Улс төр, эдийн засгийн хууль эрх зүйн тогтолцоог өөрчлөх хэрэгтэй гэсэн Хүрэлбаатар гуайн саналыг ярих хэрэгтэй. Сангийн яамны мэргэжилтнүүдэд УИХ-д төсвийн талаар оруулахдаа өөрсдийгөө хамгаалах боломж хэр байдаг юм бол.

*Удирдлагын академи Л.Отгонтуяа:* Слайд дээрх тэмдэглэгээний талаар асууя. 2015, 2016 он дээр 6,1 их наяд, 6,6 их наяд орлоготой гээд дээд талд нь 558.5 тэрбум төгрөг, 339.4 тэр бум төгрөг юм шиг байна ямар тэмдэглэгээ байсан бэ.

*Хэлэлцүүлэгт оролцогч:* Татварын бус орлогоос өмч хувьчлалын орлогоос 171 тэрбум төгрөг оруулна гэж байна. Зарим аж ахуйн нэгжийн орлогыг маш бага тогтоосон байсан. Жишээ нь Хөрөнгийн биржийг 5.5 тэрбум төгрөгөөс дуудна гэсэн байна. Үүнийг яаж тогтоогоод байдаг юм бэ. Зарим нэг яамдуудын газар хэлтсийг дутуу нэгтгэсэн байна. Жишээ нь Боловсролын салбар дээр үүрэг давхардсан агентлаг, албад нэг бус байна. Төрийн байгууллагуудын гадаад томилолтын зардлыг яагаад буулгахгүй байна вэ. Яаж шийдвэрлэх вэ.

*Хэлэлцүүлэгт оролцогч:* Ирэх жилийн сонгуультай холбоотой гарах өөрчлөлтийг урьдчилан төлөвлөсөн талаар мэдээлэл өгнө үү.

*Сангийн яамны мэргэжилтэн У.Мөнхзул:* Зөвхөн орлоготой холбоотой асуултад хариулъя. Хуулинд өөрчлөлт оруулах юм бол одоогоор байхгүй. Отгонтуяа багшийн асуултанд хариулахад 558.5 болон 339.4 гэдэг нь анх төсвийн 1 дүгээр тодотголоор батлахдаа 6 их наяд 632 тэрбум төгрөг гэж баталсан бууруулсан дүнг нь харуулсан. 339.4 тэрбум гэдэг нь төсвийн хүрээний мэдэгдлээс бууруулсан зөрүү дүнг тавьсан байгаа. Өмч хувьчлалтай холбоотой асуултын хувьд үнэлээд тооцохдоо балансын үнийг тавьсан байх, сайн мэдэхгүй байна. 5.5 тэрбум төгрөг тавьсан ч гэсэн тэр үнээрээ зарна гэсэн үг биш, өмч хувьчлалын зарчмаар л явна. Сэтгүүлчид болон иргэд та нар алтнаасаа ийм орлого орно гэж төлөвлөсөн байна. Үүнийгээ яагаад

авахгүй байгаа юм гэдэг. Төлөвлөгөө, бүртгэл 2 зөрнө. Магадгүй орлогын хэмжээ буурах үед та нар том компаниудаас татвар авахгүй байна гэдэг асуудал тавигддаг.

*Байгаль орчин, иргэний зөвлөл Оюунчимэг:* Уул уурхайгаа эдийн засгийн гол хүчин зүйл гэж үзээд байдаг. Гэтэл Хятад улс нүүрсний хэрэгцээгээ буурууллаа гээд байдаг. Таван толгой, Оюутолгойгоо яаж тооцсон бэ. Манайх гадны компаниудыг их дэмждэг болсон. Тэднээс авах татварыг бүрэн авч чаддаг уу. Гадны компаниудаас яг бодитой орлого орж ирдэг үү. Мөнгө төгрөг, төсвийн асуудал нээлттэй явж чадаж байна уу. Ил тод байж чадаж байна уу.

*Хэлэлцүүлэгт оролцогч:* Зарлага дээр Эрдэнэт үйлдвэр ОХУ-д өгөх ногдол ашгийг идсэн гээд байгаа энэ зардал төсөвт суусан уу.

*Сангийн яамны мэргэжилтэн У.Мөнхзул:* Гадны хөрөнгө оруулагчдын төлсөн татварын мэдээлэл над дээр одоо алга. Татварын хуульд гадна, дотных компани гэж ялгасан зүйл үгүй. Харин гадны хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хуулийн дагуу зохих хөнгөлөлт үзүүлдэг. Тэр нь тодорхой хуулийн хүрээнд явагддаг.

Эрдэнэт үйлдвэрээс 10 тэрбум төгрөгийн ногдол ашиг төлөвлөсөн. Өмнөх жилүүдэд 70 орчим тэрбум төгрөг төсөвлөдөг байсантай харьцуулахад бага мөнгө.

Оюутолгой, Таван толгойн хувьд бидний төсөөлөл юм. Бас эрсдэл бий.

*Хэлэлцүүлэгт оролцогч Долгор:* Хөрөнгө оруулалт их хэмжээгээр орж ирж байгаа гэж ярьж байна. Хөрөнгө оруулалтыг хэр тооцож орлогод оруулсан юм бол. Гаднаас орж байгаа хөрөнгө оруулалт ил тод биш байгаа нь төсвийг цалгар налгар болгох эрсдэлтэй. Энэ дээр Сангийн яам ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ.

*Сангийн яамны мэргэжилтэн У.Мөнхзул:* Хөрөнгө оруулалтыг мэдээж тооцсон байгаа. Хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байгаа байдал ажиглагдаж байна. Хөрөнгө оруулалтын нийт дүн статистикийн мэдээллийн бааз дээр салбарын ангиллаар гарсан байгаа. Тэрэн дээр гадна дотны хөрөнгө оруулалтыг ялгахад хүндрэлтэй юм байналээ.

*Сангийн яамны мэргэжилтэн Б.Мөнхтуул:* Таны асуултад нэмж хариулахад хандив тусламж авч болох байгууллага, авч болохгүй байгууллага гэж байгаа. Энэ дээр хандив тусламж авч болох байгууллагаас авсан хандивыг ил тод болго, зарцуулалтыг нээлттэй зарлах шаардлагыг тавьж байгаа.

**“Монгол Улсын 2016 оны төсвийн зарлагын төлөвлөлт” (илтгэл)-** Сангийн яамны мэргэжилтэн Б.Мөнхтуул танилцуулга хийлээ.

Зарлагын төлөвлөлттэй холбоотой асуулт хариулт:

*Хэлэлцүүлэгт оролцогч:* Өмнөговь, Орхон аймгаас бусад аймгууд улсын төсвөөс санхүүжиж байгаа асуудлыг яаж шийдвэрлэх вэ. Бие дааж санхүүжилтээ бүрдүүлэх боломж байна уу. Дорноговь, Дорнод, Ховд аймгуудад уул уурхай байгаа. Ерөнхийлөгч, ерөнхий сайд, гадаад хэргийн сайдаас бусад сайдуудын гадаад томилолтын зардалыг 50 хувь бууруулах шийдвэр хэр хэрэгжиж байгаа вэ. Хэрэгжихгүй харагдаад байна.

*Байгаль орчин, иргэний зөвлөл Оюунчимэг:* Дотоодын нийт бүтээгдэхүүний орлого буурсан. Хүн амд хүртээмжтэй гэдгийг юу гэж ойлгох вэ. Эрүүл мэндийн яам

Ялалтын талбай дээр байгаа хуучин боловсролын яамыг хүүхдийн эмнэлэг болгоно гэж 6,7 тэрбум төгрөгөөр ХААН банкинд худалдсан гэсэн. Одоо ч эмнэлэг бариагүй байгаа. Улаанбаатарт нийт хүн амын 60 хувь нь төвлөрсөн. УИХ-аар төсвийг хэлэлцэж байх явцад 3 аймагт 5 соёлын төв барихаар 1,2-2,6 тэрбум төгрөг төсөвлөсөн байх юм. Тэр соёлын төвөөр хэдэн хүн үйлчлүүлдэг юм. Тэгвэл хүн амын ихэнх нь оршин суудаг нийслэл хотод нэн шаардлагатай эмнэлэг барих асуудлыг царцаадаг байх жишээтэй. Соёлын төв барих, эмнэлэг барихын аль нь хүн амд хүртээмжтэй байх вэ. АСЕМ-д зориулж хэдэн тэрбумын байшин барилга бариад байна. Хэдэн тэрбумын зарлага гарах төлөвтэй. Бид эцэст нь өртэй үлдэх үү.

Яамдуудын хоорондын уялдаа холбоо байхгүй байна. Сангийн яам, БОЯ ямар уялдаатай ажилладаг вэ. Ойн судалгаа хөгжлийн төвийг цомхотгосон ашиг тус юу байна. Манай ой 8 хувийг л эзэлж байгаа. Ой мод түймэр, хулгайд өртөж, шавьж хорхойд идэгдээд, устаад байна, ой устахаар ус ширгэнэ. Ойгоо хамгаалах асуудлыг яаж шийдэх вэ. Бас нэг асуудал манай ерөнхийлөгч НҮБ-ын чуулган дээр хүлэмжийн хийг багасгах асуудал дээр гараа өргөөд дэмжээд байсан. Гадаад улс орнууд хүлэмжийн хийнээс татгалзаад эхэлж байна. Хятад улс ч импортын нүүрсний хэрэглээгээ багасгах бодлого боловсруулаад байна. Манайх болохоор Хятадад нүүрсээ гаргана гээд баахан тоо цаасан дээр бичээд ярих юм. Энэ талаар асуух гэсэн юм.

*Монгол банкны эдийн засагч Цэнгүүнжав:* Орлого дээр хэдэн асуулт байна. Экспорт дээр хэд хэдэн эх сурвалжийг зэрэгцүүлж тавиад дундчилж авсан нь сайшаалтай боловч зарим нэг эх сурвалжуудыг орхигдуулсан юм шиг санагдаж байна. Жишээ нь жипи ноорог дээр зэсийн үнэ харьцангуй бага байх жишээтэй. Энэ дээр нэг хардлага байгаад байдаг нь харьцангуй өндөр үнэтэй эх сурвалжаас аваад тавьсан байж болзошгүй гэж үзэж байна. Таван толгойн мэдээ төсөв дээр яг хэд байгаа вэ. Өмч хувьчлалын орлого ирэх онд нэмэгдэнэ гэж байна. 2015 онд өмч хувьчлалын орлого нэлээн орж ирнэ гэж төсөвлөсөн боловч гүйцэтгэл орлого маш бага байсан. 2015 онд төсөв батлагдаж байхад ЗГ-аас Сангийн яаман дээр тодорхой аргачлалын дагуу ханшийн төсөөллийг гүйцэтгэж, ирэх оны төсөвтөө ашиглана гэж заасан байсан санагдаж байна. Одоо энэ ханшийн төсөөлөл дээр ямар байгаа вэ. Ханшийг хэд байна гэж үзсэн бэ. Зарлага дээр зарлага буурна, буурсан гээд байна л даа. Энийгээ төрийн оролцоо буурсан сайшаалтай гээд байна. Энэ ямар үндэслэлтэй вэ.

*Сангийн яамны мэргэжилтэн Б.Мөнхтуул:* Аймгууд маань санхүүжилтийн дэмжлэг бол авсаар байна. Гэхдээ Өмнөговь, Орхон, Дорноговь, Улаанбаатар, Булган, Говьсүмбэр аймгууд санхүүжилт авахгүй байгаа. Зардал бол нэмэгдэж байгаа. Цалин хөлс, чиг үүрэгтэй холбоотой, үнийн өсөлттэй холбоотой зардлууд нэмэгдэж байна. Санхүүгийн дэмжлэгийг хумих тал дээр ажиллаж байна. Цаашдаа зардлын өсөлт буурах байх гэж найдаж байна. Гадаад томилолтын хувьд төсвийн хэрэгжилтийг хангах тал дээр УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, захирамжууд, Сангийн сайдын тушаалууд үе шаттайгаар гараад явж байгаа. Үүн дээр ямар зардлыг хумих, тухайн шатны байгууллагуудад чиглэл өгөх тал дээр ажиллаж байна. Чанар хүртээмж гэж ярьж байна. Үүнд юуны түрүүнд нийгмийн талын асуудлууд илүү хамаарах байх. Сүүлийн жилүүдэд зарлагыг хумьж байгаа, зарлагыг бууруулж байгаа тал дээр эрүүл мэнд, боловсрол, халамж, асрамжийн газрууд зэрэг нэлээн эмзэг салбарын төсвөөс шууд хамааралтай байгууллагууддаа төсөв хумих бодлогыг барихгүй, аль болох иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх талаар ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын талаар хөрөнгө оруулалтын төлөөлөл өнөөдөр ирээгүй байна. Соёлын төвүүд илүү баригдаад, хүн амд хэрэгтэй эмнэлгийн барилгыг царцаагаад байна гэдэг дээр хөрөнгө оруулалтын төлөөлөл илүү ярих байсан байх.

Байгаль орчны хувьд нэлээд өөрчлөлт 2016 онд орсон байгаа. Саналууд 2015 оноос эхэлж явсан. Ойн хэлтэс гэж байгаад ойн газар болоод өргөжсөн. Хажуугаар нь ойн судалгаа, хөгжлийн төв гэж байгуулагдсан. Энэ төв нь 12 хүнтэй мөртлөө 4 хэлтэстэй байсныг 50 хувиар бууруулаад, яамны чиг үүрэг рүү оруулж төсөвт өөрчилсөн. Орон нутаг дээр байгаль орчны чиглэлээр юу хийгээд байна гэхээр 2012 оноос хойш байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь орон нутаг тухайн орлогоос байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээнд тавьж өгч байгаа. Одоогийн байдлаар улсын хэмжээнд байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал дээр 19 тэрбум төгрөг тавигдаж байна. Ойн сав газраа яаж хамгаалах вэ гэдэг нь ойн тухай хуулиар зохицуулагдаж, сум дундын ойн ... нар байгаль орчны газартайгаа хамтарч нөхөн сэргээх зардлаас ойжуулах, нөхөн сэргээх ажлыг хийх бүрэн боломжтой байгаа.

*Сангийн яамны мэргэжилтэн У.Мөнхзул:* Орлоготой холбоотой асуултад хариулъя. Таны хэлдэг үнэн. Ихэвчлэн бага үнийг түүгээд тавьсан байна гэдэг. Энэ нь нэг талын хардлагаас хамгаалах үүднээс, нөгөө талын төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гол нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг тэнцвэржүүлэх тухай хуулинд заасан байгаа. Төсөвт авч байгаа тэнцвэржүүлсэн үнэ маань 20 жилийн дундаж үнэ. Харин таны асуусан 5268 гэсэн тоо маань бидний зах зээлийн үнийн төсөөлөл. Зах зээлийн үнийн төсөөлөл, тэнцвэржүүлсэн үнийн төсөөллөөрөө бид тогтворжуулалтын сандаа мөнгө авдаг. Төсвөөс өөр тооцоо хийхдээ тэнцвэржүүлсэн орлогоороо авч байгаа. Үнийн төсөөлөл 7 хоног бүр өөрчлөгдөж байна.

Нүүрсний олборлолтын хэмжээг нэмэгдүүлж тооцсон байгаа. Өмч хувьчлалын хувьд сүүлийн 2-3 жилд өмч хувьчлалын орлого тасалдалтай явж ирсэн. Энэ жилийн хувьд өмч хувьчлалаас орох орлогыг төсөвтөө суулгаж баталчихаад байхад УИХ-аас тогтоол гаргаад шинэ жагсаалт гаргаад тавьчихаж байгаа юм. Ингээд УИХ-аас гарсан 2 шийдвэр нь хоорондоо зөрчилдөөд байгаа. Ам долларын ханшийг ирэх онд 2030 төгрөгөөр төсөөлж байгаа.

*Швейцарийн хөгжлийн агентлагийн төслийн мэргэжилтэн Баярхүү:* Орлоготой холбоотой асуулт байна. 2016 оны төсөв дээр яам агентлагуудыг нийлүүлж цомхотгож байгааг зүйтэй гэж үзэж байна. Үүнтэй холбоотойгоор цомхотголд орж байгаа хүмүүсийн нөхөн олговор тусгагдсан уу. Зардлын өсөлт гэдэг дээр маш олон хүн цомхотголд орж, нөхөн олговор нэмэгдэж байгаа асуудал дурдагдах боловуу гэж бодсон дурдагдсангүй. Энэ хүмүүст хэдэн төгрөг нөхөн олговорт өгөх вэ. Оюутолгой компаниас нөөцөөс орох орлогоос өөр орлого харагдахгүй байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар Оюутолгойгоос авахаар тусгагдсан уу. Яг ямар татварын төрлөөр хэдэн тэрбум төгрөг Оюутолгойгоос авахаар тусгагдсан бэ.

*Сангийн яамны мэргэжилтэн Мөнхтуул:* Нөхөн олговор, тэтгэмжийн зардал тусгагдсан. Бүтцийн өөрчлөлт хийгдээд явах юм бол 2016 оны нөлөөллөөр их хэмжээгээр буурахаар харагдахгүй байгаа. Харин цаашдаа энэ өөрчлөлт хийгдээд явах юм бол 2017 оноос зардлын хасалт хийгдээд явна.

*Сангийн яамны мэргэжилтэн У.Мөнхзул:* Оюутолгойтой холбоотой нөөцийн төлбөрийг төлнө. Оюутолгой компанийг ямар нэг татвараас хөнгөлж чөлөөлсөн юм байхгүй. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас Оюутолгой гэлтгүй гадна дотны компаниуд алдагдалтай ажилласан бол тухайн жилдээ аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас нөхөх эрхтэй байдаг. 2013 оны 3 дугаар улирлаас эхлээд олборлолт эхэлсэн. Оруулсан хөрөнгө оруулалт өндөр, тухайн үеийн гэрээ байгуулсан ногдол

ашиг бол байхгүй. Хөрөнгө оруулалтыг төлж дууссаны дараа энэ асуудал яригдана. Ирэх онд 303,8 тэрбум төгрөг Оюутолгойгоос орно гэж тооцсон. НӨАТ төлнө.

*Хууль бидний амьдралд ТББ:* Хөтөлбөрт суурилсан санхүүжилтийн тухай ярьсан. Энэний хяналт шинжилгээ яаж хийгдэх вэ. Сангийн яам бол өөрөө төсөв санхүүг барьдаг гол байгууллага. Өөрийнхөө баталсан, өөрийнхөө зарцуулсан хөрөнгийг өөрөө хянана гэдэг зөрчилтэй асуудал. Тэгэхээр гадны байгууллагаар хяналт, мониторинг хийлгэх нөхцөл байдал бий болох юм бол асуудлыг яаж авч явах вэ.

*Долгор:* Яам цомхотгоно гэсэн яг хэдэн жилийн дундажаар тооцсон бэ. Халамжийн чиглэлээр, нийгмийн хамгааллын чиглэлээр тодорхой стандарт байхгүй учир мөнгө нь хэт их задгай, зорилтот хүндээ хүрэхгүй байгаа зэрэгт энэ тал дээр Сангийн яамныхан та нар хяналт тавиачээ.

Сангийн яам мэдээллээ нээлттэй байлгаачээ. Нээлттэй биш байна. Стандартгүй зарцуулж байгаа зарцуулалт маш том эрсдэл болж байна.

*Сангийн яамны мэргэжилтэн Б.Мөнхтуул:* Хөтөлбөрт суурилсан санхүүжилтийг төлөвлөлтөн дээрээ нилээн төрийн сангийн нэгдсэн систем дээрээ энэ жилээс холбож эхэлсэн. Хяналт шинжилгээний хувьд төрийн сан дээр гүйлгээ гаргаж байна, төрийн сан дээр дотоод хяналт гэж байдаг. Яамны дотоод хяналтын төлөөлөл ирсэн байна. Халамжийн тал дээр 13 төрлийн халамжийн хөтөлбөр явж байна. 285 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Гэвч чинээлэг давхарга халамжийн хөтөлбөрт хамрагдаад байна.

*Сангийн яамны Төрийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Мөнхгэрэл:* Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар дотор байсан дотоод аудит, хяналт шинжилгээ, УМХГ-т байсан санхүүгийн хяналт шалгалтын байцаагч нар Сангийн яамны нэг хэлтэс болж ирсэн. Энэ зохион байгуулалттай уялдуулаад орон нутагт төсвийн ерөнхийлөн захирагч нарын дотор нь хяналт шинжилгээ, үнэлгээний газрууд ажиллаж байгаа. Мөн орон нутагт Засгийн газрын тогтоолоор санхүүгийн хяналт, аудитын алба гэж байгуулагдсан байгаа. Сангийн яамны төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар бол төсвийн ерөнхийлөн захирагч, санхүүгийн хяналт, аудитын газруудад арга аргачлалаар хангаж, мэргэжлийн зөвлөмж өгч, дотоод аудитыг хөгжүүлэх, зарим тохиолдолд хамтарсан дотоод аудит хийх зэрэг шинэлэг арга хэмжээ явуулж байна. Манай дээр Дэлхийн банкны жижиг хэмжээний дэд төсөл хэрэгжиж байна. Японы Жайкатай хамтраад дотоод аудитыг улсын байгууллагад хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайн салбарын дотоод аудит яг юунд чиглэх вэ. гэдгийг ялгаж салгаад чиглэл өгч ажиллаж байна. Төсөвтэй холбоотой хэлэлцүүлж байгаа үед 2014 оны төсвийн орлого, зарлагын төлөвт манайх дотоод аудит хийсэн байдаг. Сангийн яам огт хяналтгүй явдаг гэж үзвэл өрөөсгөл болно. Харин явж байгаа процесс маань өөрөө зөв байна уу. буруу байна уу гэдэг дээр анализ хийж үзсэн.

**“Монгол улсын 2016 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт”** (илтгэл)- судлаач Д.Баярмаа танилцуулав.

Асуулт хариулт:

*Байгаль орчин, иргэний зөвлөл Цэнгэлсайхан:* Орон нутгийн байгууллага, орон нутгийн хөгжлийн сангийн талаар юунд зарцуулах юм гэсэн талаар нарийн ойлголт

байдаггүй. Жишээ нь: Ховд аймагт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд түрүүлсэн бөхөд шагнал гардуулж байсан.

Монгол улсын хөгжлийн 3 тулгуур байна. Уул уурхай, үйлдвэр үйлчилгээ, худалдааны салбар, хөдөө аж ахуй. Гэвч өнөөдөр манай улс зөвхөн уул уурхайгаас хамааралтай байна. Яагаад хөдөө аж ахуй хөгжихгүй байна, үйлдвэр үйлчилгээ хөгжихгүй байна гэхээр арилжааны банкны зээлийн хүү маш өндөр жилийн 24 хувь. Энэ тал дээр Монгол банкны зүгээс юу ч хийхгүй байна. Энэ асуудал дээр Сангийн яамны зүгээс Монгол банктай хамтраад бодлого боловсруулах хэрэгтэй байна.

*Удирдлагын академи Л.Отгонтуяа:* Судлаач Баярмаа маань манай төсвийн дүгнэлтийг өргөн хүрээнд, олон улсын нийтлэг жишиг, улс орнуудын хандлагатай уялдуулж хийсэнд судлаачид талархаж байна. Хэдэн асуулт байна.

ДНБ-ний төсөөлөл хэр үндэслэлтэй вэ. Яагаад вэ гэхээр манай татварын ачаалал, татварын нийт орлого нь ДНБ-нд эзлэх хувиараа ч буураад байдаг. Төрийн оролцооны хувьд буюу зарлагад эзлэх хувь бараг дэлхийн дундажаас доогуур юм шиг харагдаж байгаа. Төрийн оролцоо багасаад байгаа юм шиг харагдаад байгаа, гэтэл зарлага төдийлөн бодитой буурч чадахгүй байна. Татаасын зардал 53,3 хувиар өсч байна. Нэгдсэн төсвийн гуравны нэг хувийг эзэлдэг. Гэсэн хэдийч мөнгөн дүнгээрээ өссөн үзүүлэлт харагдаж байна. УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсөв зэрэг ерөнхийлөн захирагч нарын зардлыг цааш нь харахаар цалин хөлснийх маш бага, бараа үйлчилгээний зардал өндөр, тэрнээсээ бараг илүү татаасын зардлууд яваад байна. Татаасын зардлыг юунд зарцуулагдаж байгаа нь мэдэгдэхгүй, үр дүнг тооцоход төвөгтэй. Татаасын зардлыг нэлээн сайн, манай иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн үзэх шаардлагатай. Дараагийн асуудал өмч хувьчлал. Төрийн өмчийн хороогоо хувьчлал явагдахгүй, татан буулгана, голлох чиг үүргүүдийг Сангийн яам руу шилжүүлнэ гэсэн хуулийн төсөл явж байгаа. Дээр нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас орон нутгийн өмч гэсэн болгоныг хасахаар хуулийн төсөл явж байгаа. Үндэслэлийг хайгаад олоогүй. Асуухаар Орон нутгийн өмчийн шинэ хууль гарна гэсэн. Орон нутгийн өмчөөс орох орлогогүйгээр орон нутаг яаж биеэ дааж, орон нутгийн өмчийн удирдлага яаж хангагдах вэ. энийг бас судлаачид, иргэний нийгмийнхэн анхаараасай гэж хүсмээр байна.

*Оюунчимэг:* Орон нутаг хөгжлийнхөө асуудлыг зөвхөн модоор шийдэж байна. Аймгийн иргэдийн хурлын тогтоол гарсан байна. Байгаль хамгаалагчдаа мод бэлтгэх үүрэг өгч байна. Энэ асуудлыг шийдвэрлэх. Цалин хөлсний тал дээр судалгаа байна уу. Иргэний нисэхийн нэг дарга 9 сая, Эрдэнэс МГЛ ТУЗ-ийн дарга 40 сая төгрөгийн цалинтай. Ийм өндөр цалинтай байхад ажилгүй, цалингүй, ямарч орлогогүй хүмүүс маш их байдаг. Банкны зээлийн хүү маш өндөр байна. Төсвийг зөвхөн өрөөнд сууж хийдгээ болих хэрэгтэй. Ард түмний амьдралыг судлаачээ. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтраачээ.

*Ил тод байдал сан Бямбасүрэн:* Төсвийн хөрөнгийн зарцуулалтын зөв зүйтэй эсэхэд хэр хяналт тавьдаг вэ. Бүх орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд урамшуулал гэж их хэмжээний мөнгө авдаг. Энэ байх ёстой зүйл мөн үү. Цалингийн сүлжээний ил тод байдал.

*Сангийн яам Б. Мөнхтуул:* Цалингийн асуудлаар Хөдөлмөрийн яам ажиллаж байгаа. 2014 онд шинэчилж гаргасан. Цалингийн доод жишиг гээд гаргачихдаг. Энэ байгууллага тус бүр дээр өөр өөр байгаад байна. Ялангуяа сургууль, цэцэрлэг дээр.

*Сангийн яамны мэргэжилтэн Мөнхгэрэл:* Орон нутгийн төсвөөс авч байгаа урамшуулал. Татварын байгууллага, иргэдийн хурлын төлөөлөгчид улиралд урамшуулал гээд авдаг. Татварын байгууллагаас урамшуулал авсан мэдээллийг татан авч ажилласан. Аймгуудын хувьд харьцангуй бага, нийт аймгууд нийлээд 30-40 сая төгрөг болсон. Харин нийслэлийн дүүргүүдийн хувьд үнэн бодитой асуудал байсан. Нийслэлийн болон дүүргүүдийн иргэдийн төлөөлөгчид ихэнх нь бизнесменүүд байдаг. Иргэдийн хурлын төлөөлөгчид хуралдаад төсвийн орлогоос давсан мөнгийг хувиарлах тухай яриад асуудлыг шийдвэрлээд байна. Татварын хэлтэст орлого цуглуулж байгаа татварын байцаагч нар төсвөөс үр дүнгийн гэрээгээр урамшуулал авдаг учир давхардуулахгүй талаас зохицуулж өгөх. Иргэдийн хурлын төлөөлөгч нар ч мөн адил.

*Д.Оюунбадам:* Өнөөдрийн хэлэлцүүлгийн үйл ажиллагааг ингээд хааж байна. Хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн та бүхэнд талархалаа илэрхийлье. Манай дараагийн хэлэлцүүлэг “2016 оны төсвийн тэнцэл, өрийн удирдлага” сэдвээр 11-р сарын 5-нд болох тул та бүхнийг оролцохыг урьж байна.

----- о ----- О ----- о -----